



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/174

Бат-Өлзий сум

Газар ашиглах эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт иргэн Бат овогт Гончигпэрлийн Эрдэнэчимэг (ИБ72051707)-ийн эзэмшиж буй 6221002200 нэгж талбарын дугаартай 35 м<sup>2</sup> худалдаа үйлчилгээний зориулалттай газар, "Анхилуун даль" хязгаарлагдмал хариуцлагатай компани (3556875)-ийн эзэмшиж буй 6221002145 нэгж талбарын дугаартай худалдаа үйлчилгээний зориулалттай 67 м<sup>2</sup> газар, Цоохор овогт Удвалын Батмөнх (ИБ70072014)-ийн эзэмшиж буй 6221000365 нэгж талбарын дугаартай 981 м<sup>2</sup> худалдаа үйлчилгээний зориулалттай газар, иргэн Мангут овогт Вандагчогдонгийн Буянтогтох (ИС50021511)-ын 6221002146 нэгж талбарын дугаартай, төмс, хүнсний ногооны зориулалттай 11469 м<sup>2</sup> газруудын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 40 жилээр сунгасугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Бат-Өлзий сумын Засаг даргын 2007 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 51 дугаар, 2011 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн 23 дугаар, 2007 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 46 дугаар, 2007 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн А/50 дугаар захирамжуудаар тус тус олгосон газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүйд тооцсугай.

3. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд газар ашиглах гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх, газрыг зориулалтын дагуу ашиглаж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН